

**БАТЛАВ**  
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН**  
**САЙД**



**Х.НЯМБААТАР**

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД**  
**НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН**  
**ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.7-д "Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно." гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Зургаа дахь хэсгийн "Төрийн бүтээмжийн сэргэлт"-ийн 6.5-д "Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана." гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баталснаас хойш 5 жил болж байна. Энэ хугацаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлтэд үндэслэн уг хуульд 11 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд одоо ч өөрчлөлт оруулах дараах практик шаардлага үүсээд байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна" гэж заасан бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баримтлах, нэгдэн орсон гэрээ, конвенциудын хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийн агуулга, үзэл баримтлалыг нийцүүлэх шаардлага байна. Тухайлбал, олон улсын гэрээгээр хүлээсэн Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, Олон Улсын Ромын шүүхийн дүрмийг хэрэгжүүлэхэд тухайн олон улсын гэрээг баримтлах шууд эх сурвалж болж байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад "Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно." гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцүүлэн хууль бус ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохтой холбогдсон нэмэлтийг Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт оруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Ийнхүү Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт орж байгаатай холбогдуулан энэхүү гэмт хэрэгт тагнуулын байгууллага мөрдөн шалгах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуульд хуульчлах шаардлага тулгараад байна.

Түүнчлэн Эрүүгийн хуульд Хахууль авах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэ хэргийн субъектийг өргөжүүлж байгаатай холбогдуулан авлигатай тэмц байгууллагын мөрдөн шалгах харьяалалд холбогдох өөрчлөлтийг тусг шаардлагатай байна.

3. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувийг Эрүүгийн хуулий тусгай ангид хорих ял оногдуулахгүйгээр заасан, эсхүл хорих ялын дээд хэмжээ гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг эзэлдэг бөгөөд нийгмий хор аюулаар бага эдгээр гэмт хэргийг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаа учруулсан хохирлоо нөхөн төлсөн, хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаа учруулсан хохирлоо нөхөн төлөх, хор уршгийг арилгахаа илэрхийлсэн бол эрүүгий хариуцлагаас чөлөөлж болох үндэслэлийг Эрүүгийн хуульд нэмэлт оруулахаа тусгасантай холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мө яллагдагч, шүүгдэгч хохирлоо нөхөн төлж, хор уршгийг арилгаснаар хэргий хэрэгсэхгүй болгох талаар холбогдох зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Ийнхүү хөнгөн гэмт хэргийн хохирол нөхөн төлж, хор уршгийг арилгаснаар хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг хуульчлах нь анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр шийдвэрлэх, төрийн энэрэнгүй ёсны зарчмыг хангах, нөгөөтэйгүүр шүүхийн ачааллыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

Тухайлбал, Улсын хэмжээнд 2019 онд нийт гэмт хэрэг 31524 бүртгэгдсэнээс 8265 буюу 26.2 хувийг, 2020 онд нийт гэмт хэрэг 23064 бүртгэгдсэнээс 7405 буюу 32.1 хувийг, 2021 онд нийт гэмт хэрэг 25429 бүртгэгдсэнээс 7637 буюу 30 хувийг Эрүүгийн хуулийн Арван нэгдүгээр бүлэгт заасан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Үүнээс Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй Эрүүгийн хуулийн тус бүлгийн 11.6 дугаар зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргийг харьцуулахад 2019 онд 8265 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 7391 буюу 89.4 хувийг, 2020 онд 7405 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6373 буюу 86.3 хувийг, 2021 онд 7637 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6453 буюу 84.5 хувийг Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг эзэлсэн байна.

Улсын хэмжээний гэмт хэрэгтэй Эрүүгийн хуулийн 11.6 зүйлд заасан гэмт хэргийг харьцуулахад 2019 онд 31524 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 7391 буюу 23.4 хувь, 2020 онд 23064 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6373 буюу 27.6 хувь, 2021 онд 23429 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6453 буюу 25.4 хувьтай байна.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад энэ төрлийн гэмт хэрэг сүүлийн 3 жилийн дунджаар улсын хэмжээний нийт хэргийн 28.1 хувийг, Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг гэмт хэрэгт тооцохтой холбогдох өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн Арван есдүгээр бүлэгт оруулах зайлшгүй шаардлага бий болсон.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах асуудлыг зөвхөн прокурорын саналаар шүүх шийдвэрлэхээр заасан бөгөөд энэ нь практикт шүүхийн

процесс хэт уддаг байдлаас хамааран яллагдагч оргон зайлах, үүнээс үүдэн мөрдөн байцаах ажиллагааг шуурхай, бүрэн хэрэгжих нөхцөл алдагддаг байна.

Иймд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн саналыг үндэслэн прокурор хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авч болохоор нэмэлт оруулах шаардлагатай байна.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах нөхцөл боломжийг бүрэн бүрдүүлэх үүднээс мөрдөгч бие даан шийдвэр гаргах боломжтой зарим үйл ажиллагаа, эрхийг хэрэгжүүлэх тухайд практикт дараах хүндрэл бэрхшээлүүд гарч байгаатай холбогдуулан зарим эрхийг хэрэгжүүлэх боломжийг өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Тухайлбал, мөрдөгч гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон нөхцөл байдлыг үнэлж хуульд заасан аль нэг шийдвэрийг гарган түүний дагуу мөрдөгчийн санал үйлдэн прокурорт хүргүүлж байна.

Энэ нь нэг талдаа мөрдөгчийн өөрийн бие даан гаргаж байгаа шийдвэрийг үгүйсгэн, гаргасан шийдвэрийн дагуу хариуцлага хүлээхээс зайлсхийх боломжийг бүрдүүлж, нөгөөтэйгүүр гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн шалгалтын явцад цугларсан нотлох баримтыг үнэлэн гаргах шийдвэр удааширч иргэдийг чирэгдүүлж байгаа тул хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, нээхээс татгалзах, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, нэгтгэх, тусгаарлах шийдвэрийг мөрдөгч бие даан гаргах боломжийг олгож эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явуулах нөхцөлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хэрэг бүртгэлтийн хэрэгт шалгагдаж байгаа этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, мөрдөгч хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байгаа этгээдийг албадан ирүүлэх боломжгүй байдлаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлах, улмаар ял завших боломж бүрдсэн байна.

Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай явуулах, хохирогчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх зорилтыг хангах үүднээс мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг дуудан болон албадан ирүүлэх эрхтэй байх, түүнчлэн цахим хэлбэрээр автоматээр хэрэг бүртгэлтийн хэргийн дугаар авах зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Ийнхүү мөрдөн шалгах ажиллагааны зарим эрхийг мөрдөгчид олгосноор прокурорын эрүүгийн хэрэгт тавих хяналт хязгаарлагдахгүй бөгөөд мөрдөгчийн гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, хэвээр үлдээх эрх хэмжээ хэвээр байна. Түүнчлэн прокуророос эрүүгийн хэрэгт тавих хяналт сайжирч, эрүүгийн хэрэгт зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах зэргээр ажлын ачааллын тодорхой хувийг цаасан хэлбэрээр гаргахад зарцуулагддаг байсан нь өөрчлөгдөж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны хяналт тавих үндсэн чиг үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэж, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшлэх болно гэж үзэж байна.

6.Эрүүгийн хэргийн нотлох баримт бүрдүүлэх ажиллагааны 60-70 хувийг мэдүүлэг авах ажиллагааг эзэлдэг бөгөөд хэргийг шуурхай шалгаж шийдвэрлэх ялангуяа цар тахал, онц байдал зарласан үед иргэдээс мэдүүлэг авахад хүндрэл учирч улмаар хэргийн шалгалтын ажиллагаа удааширч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байх зорилт хангагдахгүй тохиолдлууд гарч байна.

Иймд зайлшгүй тохиолдолд мөрдөгч техник технологийн дэвшлийг ашигла цахим хэлбэрээр хэргийн оролцогч нараас мэдүүлэг авах, авсан мэдүүлгийг нотло баримтын хэмжээнд үнэлэх зохицуулалтыг тусгах, түүнчлэн эрх бүхий байгууллага цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулсан лавлагаа тодорхойлолтыг нотлох баримтад тооцох зохицуулалтыг хуульчлах хэрэгцээ шаардлага тулгараад байна.

7.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний тухайд барьцааны хэмжээ, хязгаар тогтоогүйгээс дүр зоргоороо хэмжээг тогтоож, үүнийг биелүүлэх боломжгүй бол таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээгээр өөрчлөх зэрэг асуудал практикт гарч байна.

Иймд барьцааны хэмжээг тодорхой хуульчлах, түүнчлэн эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгагдаж байгаа хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагааг нэн тэргүүнд зогсоох, саад учруулахгүй байх, мөн таслан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг харгалзан хувийн батлан даалтанд өгөх албадлагын арга хэмжээг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

8.Хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа өмгөөлөгчийг хэргийн материалтай танилцах боломжтой байгаа нь бодит мэтгэлцээнийг хязгаарлахад хүргэж байгаад анхаарч, өмгөөллийн үйл ажиллагааг яллах талтай тэнцвэртэй болгох үүднээс өмгөөлөгч шүүхийн өмнөх шатанд хавтаст хэргийн материалтай танилцах, нууцлалыг хангах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч хэргийн материалтай танилцснаар мэтгэлцэх, шүүхийн өмнөх шатанд үндэслэлтэй зөв шийдвэр гаргуулах, тодорхой ажиллагаа явуулах талаар бодитой хүсэлт гаргах, үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашиг нь хөндөгсөн нөхцөлд гомдол гаргах, процессын шударга байдалд ахиц гарна гэж үзсэн.

9.Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын гэмт хэрэг, Хорин есдүгээр бүлэгт заасан Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, Авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангах бодлогыг баримтлан холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаарыг тогтоосноор нийгмийн нийтлэг хүсэл зориг хангагдах, улмаар шударга ёсыг тогтоох төрийн үйл ажиллагааны үзэл санаа хангагдана.

10.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан, тухайлбал мөрдөн байцаалтын хугацаа үндэслэлгүйгээр сунгасан, мөрдөн байцаалтыг үндэслэлгүйгээр түдгэлзүүлсэн асуудлууд ихээр гардаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн эрхийг хангах, ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах үндсэн эрхтэй." гэж заасантай нийцүүлэх

үүднээс энэ талаарх гомдлыг дээд шатны прокурор, улмаар шүүхэд гаргах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэх зохицуулалтыг нэмэх;

-Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, ард нийтийн санал асуулга явуулах болон авлигын зарим төрлийн гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалалд холбогдох өөрчлөлтийг тусгах;

-Яллагдагч, шүүгдэгч хохирлоо нөхөн төлж, хор уршгийг арилгаснаар хэргийг харэгсэхгүй болгох талаарх зохицуулалтыг Эрүүгийн хуульд нийцүүлэн шинээр тусгах;

-Яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн саналыг үндэслэх прокурор, шүүхийн шатанд прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байх өөрчлөлтийг тусгах;

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах нөхцөл боломжийг бүрэн бүрдүүлэх үүднээс мөрдөгчид бие даан шийдвэр гаргах боломжтой зарим үйл ажиллагаа, эрхийг хэрэгжүүлэх боломж олгох зохицуулалтад өөрчлөлт оруулах. Тухайлбал, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай явуулах, хохирогчийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх зорилтыг хангах үүднээс мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг дуудан ирүүлэх болон албадан ирүүлэх, мөн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх, сэргээх, эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах, мөрдөгчийн нээсэн хэрэг бүртгэлийн хэрэгт прокурорын нэгдсэн цахим бүртгэлээс дугаар олгох эрхийг нэмэх;

-Зайлшгүй тохиолдолд мөрдөгч техник технологийн дэвшлийг ашиглан цахим хэлбэрээр хэргийн оролцогч нараас мэдүүлэг авах, авсан мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх, түүнчлэн эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулсан лавлагаа, тодорхойлолтыг нотлох баримтад тооцох зохицуулалтыг хуульчлах;

-Барьцааны хэмжээг тодорхой болгох, түүнчлэн эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгагдаж байгаа хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагааг нэн тэргүүнд зогсоох, саад учруулахгүй байх, мөн таслан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг харгалзан хувийн батлан даалтанд өгөх албадлагын арга хэмжээг хуульчлах;

-Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйл заасан авлигын гэмт хэрэг, Хорин есдүгээр бүлэгт заасан Хүн төрөлхтний аюулг байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хяна шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшс шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаг шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангахтай холбоот нэмэлт оруулах;

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн эрхийг ханга үүднээс оролцогч энэ талаарх гомдлыг дээд шатны прокурор, улмаар шүүхэд гаргах гомдлыг хянах процесстой холбоотой зохицуулалтыг тусгах;

-Өмгөөлөгч шүүхийн өмнөх шатанд хавтаст хэргийн материалтай танилцах нууцлалыг хангах зохицуулалтыг тусгах.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл арилж, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшилнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

**Дөрөв.Хууль төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, Монгол Улсын олон Улсын гэрээ, бусад хуультай уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.